



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 23

№ 0150 ДЧА - 2018/186/СТА - ТЧЗ Мандалговь хот

Г

Зөрчил арилгуулах тухай

Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аudit хийх явцад нийт 2,343,212 /Хоёр сая гурван зуун дөчин гурван мянга хоёр зуун арван хоёр/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Байгууллагын үндсэн цалингийн зардлаас гэрээт ажилтнуудын үр дүнгийн урамшуулал, цалингийн зардал, нийгмийн даатгалын шимтгэлийн нийт 1,236,046 /нэг сая хоёр зуун гучин зургаан мянга дөчин зургаан/ төгрөгийг төлж, зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн тайлбар хэсэгт /... үндсэн болон нэмэгдэл цалин, түүнтэй адилтгах орлогоос толох нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тооцож энэ ангилалд бүртгэнэ. Эдгээр зардлыг бүлгийн дүнгээр хянана/ заасныг тус тус зөрчсөн байна.

2. Гэрээт ажилтанд үр дүнгийн урамшуулал олгож, нийт 1,107,166 /нэг сая нэг зуун долоон мянга нэг зуун жаран зургаан/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн төвийн ажилтанд нэмэгдэл, мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-т /Нэмэгдэл болон монгон урамшилыг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажилаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгоно. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын дагуу нэмэгдэл, мөнгөн урамшил олгож болно/ заасныг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрхзүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т

/Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага огог/ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, дээрх зөрчлүүдийг таслан зогсоох;

Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Өндөршил сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Эрдэнэчuluун, нягтлан бодогч Б.Сайхантуяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан түшсаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан түшсаалтанд хүргүүлнэ/